

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 10

Арвайхээр

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1							
Төрийн байгууллагаас гарч буй бодлого шийдвэрийн төлөвлөлт хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлнэ.							
1	Зорилт 1: Үр дүнд суурилсан төлөвлөлт, хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн системийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.	-	-Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулсан эсэх -Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэн ажилласан байдал		Эхний хагас жилд: -Нутгийн захиргааны байгууллагуудыг мэдээллийн цахим санд холбож ажилласан байна.	Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэх зорилгоор бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг мэдээлэх, тайлагнах мэдээллийн цахим санг шинээр нэвтрүүлээ. Цахим мэдээллийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн бүртгэл, хяналт, зохион байгуулалт, тайлагналтын хүрээнд бүх сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын түвшинд хэрэгжүүлж эхлээд байна.	90.0 хувь
1.1	Арга хэмжээ:		-Цахим	Цахим	Цахим	Аймгийн хэмжээнд иргэдийн	

	Аймгийн хэмжээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг үнэлэх, мэдээлэх, тайлагнах мэдээллийн цахим санг шинээр нэвтрүүлнэ.		мэдээллийн санд холбогдсон байгууллагын тоо -Мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	мэдээллийн санг шинээр нэвтрүүлсэн.	мэдээллийн санд бүх сумдын ЗДТГазар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг холбож, ашиглалтын үйл ажиллагааг нь тогтмолжуулсан байна.	Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг үнэлэх, мэдээлэх, тайлагнах мэдээллийн цахим санг “Очир-Ай гүүг” ХХК-аар гүйцэтгүүлэн үйл ажиллагааг эхлүүлээд байна. Уг цахим сан нь 3 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар холбогдох тайланг тус цахим сангаар нэгтгэн авах ажлыг эхлүүлээд байна.	100.0 хувь
1.2	Арга хэмжээ: Сумдын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ хийх, арга зүйн зөвлөмжөөр хангана.		-Явцын хяналт-шинжилгээ хийгдсэн сумын тоогоор -Явцын хяналт-шинжилгээ хийсэн байгууллагын тоо	2024 оны байдлаар 5 сум, 3 агентлагийн үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ хийгдсэн.	Эхний хагас жилд: 5 сум, 2 агентлаг	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Сант, Баянгол, төгрөг сумдын Засаг даргын Тамгын газар болон бусад төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Хяналт-шинжилгээг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, Төрийн албаны стандарт, албан хэрэг хөтлөлт, байгууллагын нээлттэй байдлын	70.0 хувь

						хүрээнд үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөмж өгч ажиллав. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 3 агентлагийн үйл ажиллагаанд 6 дугаар сард багтаан хяналт-шинжилгээ хийхээр ажиллаж байна.	
1.3	Арга хэмжээ: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ хийнэ.		-Хяналт-шинжилгээ хийгдсэн эсэх -Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр -Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн цахимд санд байршуулсан эсэх	2024 оны жилийн эцсийн байдлаар 93.7 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн.	Эхний хагас жилд: Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд явцын хяналт-шинжилгээ хийж ажилласан байна	Хугацаа болоогүй.	-
1.4	Арга хэмжээ: Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мөрөөр гүйцэтгэл сайжруулах үүрэг чиглэл өгч,		-25 агентлаг, 19 сумдад зөвлөмж өгч ажилласан эсэх -Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан	Бүх сум, агентлагууд тус бүрт зөвлөмж өгч ажилласан.	Эхний хагас жилд: Бүх сум, агентлагт зөвлөмж өгч ажилласан байна.	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 01 дүгээр улиралд ажлын хэсгүүд сум, агентлагийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн 24 агентлаг, 19 сумдад зөвлөмж хүргэсэн. Төлөвлөгөөний дагуу 03 сард	100.0 хувь

	хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.		байдал			Сант, Баянгол, Төгрөг сумдад зөвлөн туслахаар ажилласан.	
1.5	Арга хэмжээ: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас аймгийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжтэй уялдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.		-Төлөвлөгөө боловсруулсан эсэх -Төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцон ажилласан байдал	2023 оны тайланд ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг тооцон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнасан.	Эхний хагас жилд: -Зөвлөмжийн дагуу ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байна.	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас аймгийн 2024 үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмж ирүүлээгүй байна. Хугацаа болоогүй.	-
2	Зорилт 2: Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааг тогтмолжуулж, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээний орон нутгийн чадавхийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.		-Хяналт-шинжилгээ, үнэлгээний орон нутгийн эрх зүйн зохицуулалт хийгдсэн байдал -хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байгууллагын тоо -хүргүүлсэн зөвлөмжийн тоо	-2024 оны үйл ажиллагааны ХШҮ-ний дүнгээр 5 сум, 3 агентлаг шалгарсан. -19 сум, 23 агентлагт зөвлөмж хүргүүлсэн.	-Журмууд боловсруулагдан батлагдсан байна. -ХШҮ-ний дүнгээр 5 сум, 3 агентлаг шалгаруулна. -19 сум, 23 агентлагт зөвлөмж хүргүүлнэ.	Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хяналт шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу орон нутгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг боловсруулагдаж байна. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 1 дүгээр улиралд ажлын хэсгүүд 19 сум, 24 агентлагийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүн, үр нөлөөг үнэлэн журмын дагуу 3 агентлаг, 5 сум	80.0 хувь

						шалгаруулж, тус бүр зөвлөмж хүргэж ажилласан.	
2.1	Арга хэмжээ: Засгийн газрын шийдвэрийн дагуу байгууллагын гүйцэтгэлийн удирдлагын хэрэгжилтийг дүгнэх, үнэлгээ, мониторинг хийх нийтлэг журмыг үндэслэн орон нутгийн журмыг боловсруулах		-Журам боловсруулагдсан эсэх (тийм/үгүй) -Журмыг танилцуулах, холбогдох байгууллага, албан тушаалтнуудыг мэдээллээр хангах		<i>Эхний хагас жилд:</i> Журмуудыг шинэчлэн боловсруулж, аймгийн Засаг даргын шийдвэрээр баталсан байна.	Хугацаа болоогүй	-
2.2	Арга хэмжээ: Байгууллагын дотоод хяналтын нэгжийг шинэчлэх, үйл ажиллагааны чиглэлийг боловсруулах		-Бүрэлдэхүүнийг шинэчилсэн эсэх -Үйл ажиллагааны чиглэлийг боловсруулсан эсэх		<i>Эхний хагас жилд:</i> Нэгжийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, үйл ажиллагааны чиглэлээ боловсруулсан байна.	Байгууллагын дотоод хяналтын нэгж, нэгжийн үйл ажиллагааг чиглэлийг боловсруулах ажил хийгдэж байна.	70.0 хувь
2.3	Арга хэмжээ: Байгууллагын дотоод хяналтын нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллана.		-Төлөвлөгөө боловсруулагдсан эсэх -Хэрэгжилтийг дүгнэж ажилласан байдал		<i>Эхний хагас жилд:</i> Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байна.	Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдаж байна.	70.0 хувь

2.4	Арга хэмжээ: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын ЗДТГ-ын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.		-ХШҮ-нд хамрагдсан сумын тоо -ХШҮ-нд хамрагдсан байгууллагын тоо	Журмын дагуу 5 сум, 3 агентлагийг шалгаруулсан	Эхний хагас жилд: 5 сум, 3 агентлаг	Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Арвайхээр, Хорхорин, Уянга, Хайрхандулаан, Хужирт сумдууд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Онцгой байдлын газар тус тус шалгарсан.	100.0 хувь
2.5	Арга хэмжээ: Улсын төсөвт байгууллагууд (төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд)-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, арга зүйн зөвлөмжөөр хангана		Хяналт-шинжилгээ хийж ажилласан байгууллагын тоогоор		2-оос доошгүй байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-
Стратеги төлөвлөгөөний зорилго 2							
Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд							
1.	Зорилт 1: Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр,		-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн	Хагас жил тутам хяналт-шинжилгээ,	-Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт	Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын болон орон нутгаас гарч байгаа	91.4 хувь

	төсөл, Засгийн газрын болон орон нутгаас гарч байгаа тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, эрсдэлийн удирдлагаар хангана.		хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн давтамж -Хяналт-шинжилгээ хийсэн шийдвэрийн тоо -Хяналт-шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулсан.	бичгүүдийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцон ажилласан байна. -2024 онд батлагдсан аймгийн Засаг даргын захирамжид хяналт-шинжилгээ хийж, холбогдох байгууллагад чиглэл өгч, хамтран ажилласан байна.	тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх үйл ажиллагаа тогтмолжиж, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын абримт бичгийн хэрэгжилт үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг журмын дагуу тайлант хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хяналт хэрэгжүүлэх газар болон төрийн захиргааны төв байгууллагуудад тайлагнаж, цахим мэдээллийн сан байршуулж хэвшээд байна.	
1.1	Арга хэмжээ: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийн сан үүсгэх, хэрэгжилтийн явцад хагас жил тутам хяналт шинжилгээ,		-Хяналтад авсан шийдвэрийн тоо -Хагас жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн байршуулалт,	2024 оны эхний хагас жилд 84,1 хувь, жилийн эцэст 92.3 хувийн хэрэгжилттэйг ээр тус тус тайлагнасан.	Эхний хагас жилд: Хяналтад авах шийдвэрийн тоог нэмэгдүүлж, хэрэгжилтийн дундажийг 70-аас доошгүй хувьд хүргэж ажилласан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд (www.unelgee.gov.mn) байршуулсан. Аймгийн Засаг даргад хэрэгжүүлж ажиллахаар үүрэг болгосон, даалгасан нийт 159 шийдвэрийн 296 заалтад	90.0 хувь

	үнэлгээ хийж, үр нөлөө, үр дагаварыг үнэлэх, мэдээлэх тайлагнах.		баталгаажуулалт -Сар тутам Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулсан байдал			хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийн 92.36 хувьтай үнэлэгдэв. 2025 оны 1 дүгээр улиралын байдлаар нийт 108 шийдвэрийн 164 заалтын хэрэгжилтийг журмын дагуу тайлант хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулан ажилласан бөгөөд хагас жилийн хэрэгжилтийг 07 дугаар сард тайлагнахаар бэлтгэж байна.	
1.2	Арга хэмжээ: Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнд ХШҮ-ний шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.		-Хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийг ашигласан байдал -Хяналт-шинжилгээ үнэлгээний дүгнэлт боловсруулж ажилласан эсэх	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн явц, үр дүнг 2024 оны 6 дугаар сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн.	Сүүлийн хагас жилд. Хөтөлбөрийн тайланг хугацаанд нь тайлагнаж ажилласан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр дүгнэлт зөвлөмж гарч, холбогдох байгууллагуудад чиглэл өгч ажилласан байна.	Аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилт үр дүнгийн тайланг гаргаж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2025 оны эхний улиралд буюу тайлант хугацаанд байршуулан ажилласан. Нийт 157 заалтын хэрэгжилтийн дандаж 91,5 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг 2025 оны хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.	90.0 хувь
1.3	Арга хэмжээ: Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнд		-Хяналт-шинжилгээ хийсэн тайланг хугацаанд нь байршуулж баталгаажуулсан	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2023 оны 11	Хөтөлбөрийн тайланг хугацаанд нь тайлагнаж ажилласан байна. Хяналт-	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 61 зорилт, 344 арга хэмжээг нэгтгэн дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээний	100.0 хувь

	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулах, тайлагнана.		эсэх -Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн тоо	дүгээр сарын 28-ны өдөр хэлэлцэж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний эхний 3 жилийн хэрэгжилт, үр дүнг 86.8 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэгдсэн.	шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр дүгнэлт зөвлөмж гарч, холбогдох байгууллагуудад чиглэл өгч ажилласан байна	тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцүүлж, хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг 89.2 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг тайлант хугацаанд буюу 2025 оны эхний улиралд хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулсан.	
1.4	Арга хэмжээ: Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох байгууллагад тайлагнах, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулна.		-Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан эсэх -Тайланг журмын дагуу хугацаандаа тайлагнасан байдал	Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний нийт 112 заалтын биелэлт, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, хэлэлцүүлсэн.	Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан байна.	Хугацаа болоогүй.	-
1.5	Арга хэмжээ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн	-	-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан	Сар бүр нийт 12 удаа цахим санд байршуулж,	Эхний хагас жилд -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сар бүрийн 10-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын	100.0 хувь

	хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулах, тайлагнана.		байдлаар -Хагас жил тутам тайлагнаж, баталгаажуулсан эсэх	тайлагнасан.	тайланг цахим санд байршуулж, баталгаажуулан ажилласан байна.	хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулан, хугацаанд нь баталгаажуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан аймаг, орон нутагт хамаарал бүхий 5 бүлэг, 62 зорилт, 117 арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн үнэлгээг 92.8 хувьтай дүгнэж Хяналт хэрэгжүүлэх газарт хугацаанд хүргүүлж, цахим санд байршуулсан.	
1.6	Арга хэмжээ: Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулна.	-	-Байгуулсан гэрээний тоогоор -Бүх гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийгдсэн эсэх	2024 онд Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай нийт 19 гэрээ хийгдэж, гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн ажилласан.	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч 24 сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлант хугацаанд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газрын хяналт-	2025 оны эхний хагас жилийн байдаар нийт Засгийн газрын 8 гишүүнтэй байгуулсан гэрээний биелэлтийг тайлангахаар гэрээнд тусгагдсан бөгөөд дээрх гэрээний биелэлтийг тайлагнах ажил хийгдэж байна. 6 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар нийт 2 сайдын гэрээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтээр тооцон гаргаж хүргүүлээд байна.	90.0 хувь

					шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулсан байна.		
1.7	Арга хэмжээ: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан шийдвэрийн хэрэгжилт үр дүнг холбогдох шатны хурлаар хэлэлцүүлнэ.	-	-Хяналтад авагдсан шийдвэрийн заалтын тоогоор -Холбогдох шатны хурлаар хэлэлцүүлсэн байдал	2024 оны жилийн эцсийн байдлаар 117 шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнасан.	Сүүлийн хагас жилд: Аймгийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөл болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн байна.	Төлөвлөгөөний дагуу Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрүүдээс цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, хууль тогтоомжийн хүрээнд хүчингүй болгох шийдвэрүүдийн жагсаалтыг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл, Хороодын хурал, ээлжит 5 дугаар хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, нийт 5 шийдвэр хүчингүй болгосон тогтоолыг батлуулсан. Мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон нийт 15 шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 5 дугаар сард тус хурлуудаар хэлэлцүүлсэн.	100.0 хувь
1.8	Арга хэмжээ: Аймгийн Засаг даргаас гарсан шийдвэрт хяналт- шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтныг мэдээллээр хангана.	-	-Хяналт- шинжилгээ хийсэн шийдвэрийн тоо -Хяналт- шинжилгээний мөрөөр өгсөн чиглэл, зөвлөмж	-	Эхний хагас жилд: Аймгийн Засаг даргын захирамжид хяналт-шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудад чиглэл өгч, хамтран ажилласан байна.	Хугацаа болоогүй	-

1.9	Арга хэмжээ: Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, тайлагнана.	-	-Тайлагнасан хөтөлбөрийн тоо -Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хувь өмнөх оноос өссөн, буурсан үзүүлэлт.	-	-	Хугацаа болоогүй.	-
1.1 0	Арга хэмжээ: Хэрэгжих хугацаа дууссан дэд хөтөлбөрт үр нөлөөний үнэлгээ хийнэ.	-	-Хөтөлбөрийн тоогоор -Холбогдох дээд шатны байгууллагад тайлагнасан байдлаар	-	2-оос доошгүй хөтөлбөрт ХШҮ хийж ажилласан байна.	Хугацаа болоогүй	-
1.1 1	Арга хэмжээ: Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдах төслүүдийн төлөвлөлтөд хяналт-шинжилгээ хийх	-	Боловсруулагдсан төслийн тоо	-	7-оос доошгүй хөтөлбөр боловсруулагдсан байна.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны “Хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор Багшийн хөгжил хөтөлбөр баталсан. Хайрлагдсан хүүхэд, Халуун ам бүл төслүүд боловсруулагдаж байгаа бөгөөд 6 дугаар сард багтаан батлуулахаар ажиллаж байна.	70.0 хувь
2.	Зорилт 2: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад хувийн хэвшил, иргэний	12,0 сая	-Хийгдсэн судалгааны тоо -хамрагдсан иргэд, албан хаагчдын тоо	-	6-аас доошгүй судалгаа хийж, дүгнэлтэд үндэслэн бодлогын	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн иргэдийн сэтгэл ханамжийн болон төрийн албан хаагчтай холбоотой асуудлаар	100.0

	оролцоот хяналтыг хэрэгжүүлнэ.		- Судалгааны дүгнэлтээс үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн		төлөвлөлт хийж, хэрэгжүүлэлтэд хяналт тавьж ажилласан байна.	судалгааны ажлуудыг шат дараатай зохион байгуулж, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч байна.	
2.1	Байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар улирал тутам үнэлүүлж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх	12.0 сая	-Хамтран ажилласан байгууллагын тоо -Хийгдсэн сэтгэл ханамжийн судалгааны тайлан -Судалгаан дээр үндэслэн авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	-	4-өөс доошгүй удаагийн судалгаа хийгдэж дүгнэлт гарсан байна.	Хугацаа болоогүй.	-
2.2	Нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдаас байгууллага дээрх ёс зүйн зөрчил, дутагдлын талаар судалгаа авч, нэгтгэн дүгнэх, холбогдох албан тушаалтнуудыг мэдээллээр хангах	-	-Судалгаа хийсэн байгууллагын тоо -Судалгаанд хамрагдсан албан хаагчдын тоо -Судалгааны тайлан, дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	10-аас доошгүй байгууллагыг хамруулан судалгаа хийж, дүгнэлт гаргасан байна.	Төрийн албан хаагчдын ёс зүй болон ажлын байрны дарамтын талаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын дунд судалгаа авч ажилласан бөгөөл нийт 19 агентлагийн 263 албан хаагч хамрагдсан байна. Судалгааны дүнгээс харахад, байгууллагын ёс зүй, удирдлагын хариуцлага, бэлгийн дарамтын асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Судалгаанд оролцогчдын санал, хүсэлтүүдийг үндэслэн ёс зүйн хэм хэмжээг сайжруулах, сургалт зохион байгуулах, удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.	100.0 хувь

3.	Зорилт 3: Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг нэмэгдүүлж, хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхийг бэхжүүлнэ.	-	-Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны тоо	2024 онд 4 удаагийн сургалт зохион байгуулж, 120 орчим албан хаагчдыг хамруулсан.	<i>Эхний хагас жилд:</i> -Гаргасан дүгнэлт, зөвлөмж нь хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. <i>Сүүлийн хагас жилд:</i> -Хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавх сайжирч, үйл ажиллагаанд ахиц гарсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад арга зүйн зөвлөмж өгч ажиллав. Байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан цаг үеийн чанартай ажлуудад оролцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэн ажилласан.	87.5 хувь
3.1	Арга хэмжээ: 5-аас доошгүй сумдын Засаг даргын 2024 оны захирамжид хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлнэ.	-	-Хамрагдсан сумын тоо -Хяналт-шинжилгээ хийсэн захирамжийн тоо -Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	-	<i>Эхний хагас жилд:</i> -5-аас доошгүй сумдын Засаг даргын захирамжид хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж өгч ажилласан байна.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	-
3.2	Арга хэмжээ: Хэлтсийн үйл ажиллагааг сурталчилах, цахим сайтад холбогдох мэдээллүүдийг байршуулна.	-	-Байршуулсан мэдээллийн тоогоор -Мэдээлэл авсан иргэдийн тоогоор	-	Үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд нээлттэй хүргэж ажилласан байна.	Хэлтсийн 2025 оны төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн хяналтад авсан бүртгэл, Засгийн газрын тогтоол шийдвэр, Ерөнхий сайдын албан даалгавар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын шийдвэр зэргийг Uvurkhanga.gov.mn вэб сайтад цаг тухайд нь байршуулан ажиллаж байна.	90.0 хувь
3.3	Арга хэмжээ: Албан хаагчдыг ажлын байран дээрээ	-	-Сургалт хөгжлийн арга хэмжээнд	-	-Албан хаагчдыг холбогдох сургалтад	Монгол хэлний тухай хуулийн 7.2 дахь заалт, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хүрээнд	90.0 хувь

	сурах, дадлагажих нөхцөлийг бүрдүүлж, албан хаагчдын монгол бичгийн мэдлэгээ нэмэгдүүлж бие даан суралцах боломжийг хангана.		хамрагдсан албан хаагчдын тоогоор -Зохион байгуулагдсан сургалт, арга хэмжээний тоогоор		хамруулж, чадавхжуулсан байна.	2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхэлсэнтэй холбогдуулан батлагдсан төлөвлөгөөний дагуу албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор байгууллагуудын дунд "Монгол бичиг"-ийн түвшин тодорхойлох судалгаанд хамрагдаж оролцсон.	
3.4	Арга хэмжээ: Монгол бичгээр баримт бичиг боловсруулах стандартын дагуу албан бичгийг монгол бичгээр гаргах.	-	Монгол бичгээр гаргасан албан бичгийн тоогоор	-	Хэлтсээс гаргаж байгаа бичгийг монгол бичгээр гаргаж ажилласан байна.	Эхний хагас жилийн байдлаар нийт 6 албан тоот төлөвлөж явуулснаас 4 тоотыг монгол бичгээр төлөвлөж гаргасан байна.	100.0 хувь
3.5	Арга хэмжээ: Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудыг чадавхжуулах, сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулна.	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоогоор -Зохион байгуулагдсан сургалтын тоогоор	2024 онд 4 удаагийн сургалт зохион байгуулж, 120 орчим албан хаагчдыг хамруулсан.	-Нийт байгууллагын 10-аас доошгүй хувийг хамруулж, албан хаагчдыг чадавхжуулсан байна.	Сумдын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтнүүдийг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээний орон нутгийн цахим сангийн ашиглалтын талаар арга зүйн мэдээлэл өгөв. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Хяналт шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмыг хэрэгжүүлэх асуудлаар 5 сумын ЗДТГазар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 3 агентлагийн албан хаагчдад мэдээлэл өгч ажиллав.	70.0 хувь

						Тус журмуудын талаарх арга зүйн нэгдсэн сургалтыг сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг хамруулах зохион байгуулахаар төлөвлөж байна.	
--	--	--	--	--	--	---	--

Төлөвлөгөөг үнэлсэн:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
(албан тушаал)
(огноо)
Тэмдэг
.....


Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ,
үнэлгээний хэлтсийн дарга
(албан тушаал)
(огноо)
.....

Тайлагнасан:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ,
үнэлгээний хэлтсийн дарга
(албан тушаал)
(огноо)
.....

Төсвийн шууд захирагч


.....
(гарын үсэг)

(Ц.Ганболд)

Нэгжийн дарга


.....
(гарын үсэг)

(Т.Үржинпүрэв)

Нэгжийн дарга


.....
(гарын үсэг)

(Т.Үржинпүрэв)